

ТҮҮХЧИЙН ИНДЭР

**«1911 ОНЫ ҮНДЭСНИЙ ЭРХ
ЧӨЛӨӨНИЙ ХУВЬСГАЛЫН 80
ЖИЛИЙН ОЙ» ДУГУЙ ШИРЭЭНИЙ
ЯРИЛЦЛАГА**

Энэ онд манай ард түмэн ардын хувьсгалын 70 жилийн ойн зэрэгцээ энэхүү хувьсгалын эхлэл, орчин үеийн Монгол улсын сэргэн мандалтын эхэн болсон цагаагчин гахай жилийн буюу 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын 80 жилийн ойг ёслон тэмдэглэж байна. Түүхт ойд зориулан тус сэтгүүлийн редакцаас ШУА-ийн Дорнодахин, олон улс судлалын хүрээлэн, Түүхийн хүрээлэн, Философи, социологийн хүрээлэн, МУИС-ийн багш эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтнуудыг урьж ярилцлага зохион явуулав. Ярилцлагад Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, түүхийн ухааны дэд эрдэмтэн Л. Жамсран хийсэн судалгаагаа үндэслэн сонсгол тавьж шинэ санаа, дүгнэлтээ дэвшүүлж хэлэлцүүлэв.

**МОНГОЛЫН ЦАГААГЧИН ГАХАЙ
ЖИЛИЙН ХУВЬСГАЛ****Л. Жамсран**

Бид Монгол он тооллоо төдий л өргөн хэрэглэхгүй, аргын тооллыг голлох болсон тул цагаагчин гахай жилийн хувьсгал гэх нь харийн юмыг монголынх гэсэн шиг санагдаж болох юм. Гэтэл монголчуудын дээд өвөг Хүн (Хүннү) нар 2200 жилийн тэртээ тулгар төр байгуулснаас хойш монгол нутагт оршин тогтнож байсан улс бүхэн билгийн он тооллыг хэрэглэсээр ирсэн тул «цагаагчин гахай жил» бол харийн биш харин манайх бөгөөд 1911 он юм. Монголд тэр жил болсон үйл явдал бол Монголын сэргэн мандалтын үеийн эхэн бөгөөд түүнээс хойш цагаагчин тахиа жил (1921), цагаан морин жил (1990)-д болсон үйл явдлууд нь түрүүчээрээ бэлтгэгдэж шинж чанараараа харилцан адилгүй хувьсгалууд байсны түрүүч болох цагаагчин гахай жилийн хувьсгалын тухай, өөрийн судалгааг үндэслэн дэвшүүлж байгаа шинэлэг санал дүгнэлтээ та бүхэнд толилуулж санал солилцмоор байна.

Та бүхэн түүхийн энэ үйл явдлыг сайн мэдэх, мэргэжилтнүүд тул үүний явцыг ярихгүй. Зөвхөн юуг үндэслэж, түүхийн үнэнийг сэргээх Ямар шинэ санаа гаргаж байгаагаа хэлэх нь зүйтэй болов уу? Үүнд:

1. Цагаагчин гахай жил монголчууд тусгаар тогтнолоо тунхаглан Монгол улсаа сэргээн байгуулсныг зарим түүхчид Хаант Орос улсын турхиралтаар Богд Жавзандамба тэргүүтэй цөөн язгууртны хуйвалдаан гэж байхад нөгөө зарим нь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн гэх зэргээр хоёр янзаар тодорхойлон бичиж байна. Үүний эхнийх нь Монгол Чин улс ба түүний суурин дээр тогтсон Дундад иргэн улсын захиргаанд байх ёстой гэдгийг иш үндэс болгож байгаагаас түүхийн үнэнд гоомой хандаж ийм дүгнэлт хийж байна. Сүүлчийнх нь монголчууд угаасаа тусгаар улс байсны хувьд харь Манж-Хятадын ноёрхлоос гарахын төлөө тэмцэх нь зүй ёсны хэрэг хэмээн үздэг түүхчид - Мөнхүү үйл явдлыг үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн гэж тодорхойлж байна. Би үүний сүүлчийнхийг дэмжиж байгаа боловч зөвхөн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн гэх нь хэтэрхий ерөнхий бөгөөд учир дутагдалтай.

Түүнийг тодруулж, уг болсон үйл явдлын мөн чанарыг илрүүлэх хэрэгтэй. Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн гэдэг бол харийн ноёрхлоос гарахын төлөө гарч буй олон нийтийн тэмцлийг хэлдэг ерөнхий нэр. Тэгвэл монголчууд Чин улсын ноёрхлыг түлхэн унагаж өөрийн улсыг байгуулсан болохоор уг үйл явдлыг үндэсний эрх чөлөөний хувьсгал гэвэл зохино. Ер нь аливаа хувьсгалын гол асуудал бол засгийн эрхийг авах явдал байдаг. Тэгвэл энэ зорилт түр боловч хангагдсан.

2. 1911 оны 12 дугаар сарын 29-нд улсын хааныг хаан ширээнд өргөмжилж, тунхагласан улс, байгуулсан засгийн газрыг түүхэнд тоглоомын улс, тоглоомын засгийн газар гэж монголын тусгаар тогтнолын эсрэг түүхчид элдвээр нэрлэж бичсэн байхаас гадна улс гэхгүй автономит монгол гэж хаант Орос улсын нэрлэж байсан дагуу Зөвлөлт, Монголын түүхчид бичдэг байлаа. Харин 60-аад оноос Богд хаант Монгол улс гэж бичдэг болсон нь тус сэдвийн судлалд гаргасан ахиц мөн боловч бас учир дутагдалтай юм. Жавзандамба хутагт 1911 оны 12 дугаар сарын 29-нд Монгол улсын хаан ширээнд өргөмжлөгдөөд буулгасан зарлигтаа: «шашныг мандуулан, амьтныг жаргуулагч, олноо өргөгдсөн Монгол улсын эзэн, шашин төрийг хослон баригч Наран гэрэлт богд хааны зарлиг» гэсэн байдаг. Тэгвэл энд «Олноо өргөгдсөн Монгол» улс гэдэг нэр гарч байна. Уг үйл явдлыг нүдээр үзсэн Чойбалсан Догсом, Лосол нар өөрсдийн зохиолд «Олноо өргөгдсөн Монгол улс» гэж бичсэн байдаг. Энэхүү «олноо өргөгдсөн» гэдэг нэр Энэтхэг, Төвдөөс Монголд нэвтэрсэн бөгөөд бүх монголчуудын санаа зоригийн дагуу байгуулагдсан гэсэн санааг илэрхийлж байгаа нь бидний үндэсний эрх чөлөөний хувьсгалын ялалтын дүнд байгуулагдсан улс гэж нотолж байгаатай тохирч байна. Монголчуудын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өмөг түшиг болж байсан Хаант Орос улс маань бүх монгол нэгдэж тусгаар улс болохыг дэмжихгүй байснаас улсын цол олноо өргөгдсөн гэснийг бас зөвшөөрөхгүй байлаа. Иймээс тэр нэр зөвхөн оны цолд хэрэглэгдэх болсон болов уу? Богд Хаант Монгол улс гэдэг нэр нь зохиомол бөгөөд зөвхөн Жавзандамба хутагтыг шүтэж өргөмжилсөн чанартайгаас биш, түүнд олноо өргөгдсөн эсвэл шашин төрийг хослон барьсан гэдэг утгыг илэрхийлэхгүй байгаа учраас зохимжгүй байна. Иймд түүхийн үнэнийг сэргээж 1911—1915 оны Монгол улсыг Олноо өргөгдсөн Монгол улс гэж нэрлэж байх нь зүйтэй. Эртнээс түүхтэй Монгол улсын нэг хэсэгхэн үеийн агуулгыг зөв илэрхийлэх юм.

3. Монгол, Зөвлөлтийн түүх судлалд бидний өгүүлэн буй үйл явдлыг 1911—1912 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн гэж үзсээр байгаа нь түүхийн үнэнд нийцэхгүй байгаа юм. Юу гэвэл юуны урьд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн гэж ерөнхий нэрлэх биш, харин түүний мөн чанарыг илэрхийлэн үндэсний эрх чөлөөний хувьсгал гэж байх саналыг дээр дэвшүүлснээс гадна түүний үргэлжилсэн хугацааг 1911-1912 он гэж үзэх нь бодит үнэнд нийцэхгүй байна. Яагаад гэвэл халх барга, цахар, урианхай, дөрвөд зэрэг олон монгол угсаатны нэгдсэн зэвсэгт хүчин 1912 оны 8 дугаар сард Ховдыг чөлөөлснөөр Ар Монголын нутаг Чин улсын захиргаанаас бүрэн чөлөөлөгдсөн юм. Үүгээр үндэсний эрх чөлөөний хувьсгалт тэмцэл дууссан гэж үзэх нь 1911 онд Чин улсын ноёрхолд байсан олон монголчууд төрийн тусгаар тогтнолоо сэргээх олноо өргөгдсөн Монгол улс байгуулан, түүний захиргаанд нэгдэхийн төлөө тэмцэж байсныг үгүйсгэж зөвхөн Ар Монголд гарсан хөдөлгөөн мэтээр харуулахыг оролдож байсан. Ингэснээр Монгол орныг «хувааж ноёрхох» түрэмгий бодлого явуулдаг улсуудын сонирхолд нийцэж байгаа юм. Гэтэл хэргийн үнэн байдал гэвэл Юань Шикай тэргүүнтэй цэргийн эрхтнүүд Хятадын хувьсгалыг цус урсган дараад

Өвөр Монголд өрнөж байгаа тусгаар тогтнолын хөдөлгөөнийг дарах, улмаар Олноо өргөгдсөн Монгол улсыг устгах явууллага хийж эхэлмэгц Монгол улс 1913 оны эхээр хятад цэргийн довтолгооныг няцааж Өвөр Монголыг чөлөөлөх, Манлай баатар жанжин Дамдинсүрэнгийн удирдлагаар монгол угсаатны нэгдсэн зэвсэгт хүчин таван замаар хөдөлгөж орон нутгийн босогчдын хүчтэй хавсран монгол нутаг орныг амжилттай чөлөөлж байхад Орос, ДИУ хоёр 1913 оны эцсээр гадаад Монголын автономийн тухай тунхаглал гаргаж монголчуудын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг тасалдуулсан билээ. Үүгээр монголын үндэсний эрх чөлөөний хувьсгалын 1911—1913 оны өрнөлт аргагүй буурч улмаар 1915 оны гурван улсын гэрээ гэгчээр Монголын тусгаар тогтнол цуцлагдаж зөвхөн Ар Монгол, ДИУ-ын харьяанд автономит эрхтэй байх болоод хэрэг дээрээ Орос улсын колони болсноор цагагчин гахай жил эхэлсэн монголын үндэсний эрх чөлөөний хувьсгал ялагдсан гэж үзэж байна.

Б. Лхамсүрэн, (ШУА-ийн гишүүн). Монголын тусгаар тогтнолыг тунхаглахад хүргэсэн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ХХ зууны эхнээс үр хөврөлтэй, өрнөлт бууралтай байсан талаар н. Жамсрангийн дэвшүүлсэн санааг зүйтэй гэж үзэж байна. Энэ хөдөлгөөний эх сурвалж нь Манж чин улсын эцсийн улиралд Монголыг колоничлох бодлого хүчтэй болсонтой холбоотой, түүний цаашдын өрнөл, буурал нь Хятад улсын зүгээс уул бодлогыг элдэв хэлбэрээр үргэлжлүүлсэн үйл явууллагатай уялдаатай байв. Иймд уул хөдөлгөөний үр дүнд олон улсын эрх зүйн субъектийн хувьд Монголын тусгаар тогтносон асуудлыг авч үзэхдээ түүний дотоод гадаад бодлогын үндэслэл, гадаад харилцааны баримт бичиг, үйл ажиллагааг нарийвчлан судлах нь чухал.

1911-1912 оны үед үүсэн тогтсон Монгол улсыг хэрхэн нэрлэх нь түүний мөн чанар, хэлбэрийг ялган салгаж, нягтлан үзэхээс болно. Мөн чанарын хувьд шашин төрийг хослон баригч Богд Жавзандамбаар толгойлуулсан хэмжээгүй эрхт хаант засаг тогтож байсан учир төр үеийн манай улсыг Богд хаант Монгол улс гэж нэрлэсэн нь оновчтой болсон болов уу. Олноо өргөгдсөн гэдэг нэр нь Богд гэгээн болон түүнийг хаанд өргөмжилсөн он тоололд холбогдох билээ. Хиагтын хэлэлцээрээр Монгол улсын бүрэн эрхийг хязгаарласнаас хойш ч уул цол хэвээр байсан. 1921 оны ардын хувьсгалын дараа ч Богдыг Монгол улсын хэмжээт эрхт хаан болгосноос хойш 1924 он хүртэл оны цол хэвээр хэрэглэгдсээр байсныг бас бодолцох хэрэгтэй гэж үзэж байна.

Ц. Пунцагноров (ШУА-ийн гишүүн). Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцэлд Богд ямар үүрэг гүйцэтгэснийг гаргах хэрэгтэй. ҮЭЧХ-нд Богд зөвхөн оролцсон биш гол төв нь байсан. Түүхэнд Богдыг аль муу муухайгаар дүрсэлсэн байдаг, заналт дайсан гэж байв. Тухайн үеийн үзэл сурталд тааруулж л байжээ. Улсын нэрийн хувьд сүүлийн үед автономит гэдгийг хэрэглэхгүй байгаа. 1911-1915 оны хувьд Үндэсний тусгаар тогтнолын төлөө маш их тэмцэж байсан. Тэгэхлээр энэ үеийг автономит гэж хэлж болохгүй. Харин 15 оноос хойш автономит болсон. Гэхдээ хятадын биш Оросын автономит илүү байсан.

Г. Сүхбаатар (доктор). Хувьсгал бол нэг нийгмээс нөгөө нийгэмд шилжсэнийг хэлдэг байх гэж бодож байна.

Олноо өргөгдсөн гэдгийн хувьд бол тэр чинь Энэтхэгийн Махасамматыг л орчуулсан хэрэг шүү дээ. Богд хаант Монгол улс гэдэг бол зохиомол нэр. Түүхэнд ямар байсан тэрүүгээр нь л нэрлэх ёстой. Богдын хувьд бол түүний байр суурь нь өөр болох байх, гэхдээ зангилаа ч байгаагүй байх. Богдын тухай Жамсрангийн саналыг нэлээд үндэстэй гэж бодож байна.

Түүхийн үечлэлийн хувьд анхаарах хэрэгтэй. Манжид дагаар орсон уу, үгүй юу гэдгийн хувьд бол дагаар орсон уу орсон, Занабазар урвасан уу, урвасан. Сүүлийн үед түүхийг гуйвуулж байна.

Н. Ишжамц (ШУА-ийн гишүүн): Нөхөр Ц. Пунцагноров энд автономитын талаар шинэ санаа хэлчих шиг боллоо. Нээрээ Монгол улс тухайн үед Хятад, Оросын хоёулангийнх нь хараат байдалтай байсан. Тэгэхдээ тэнд Оросын нөлөө илүү хүчтэй байсан гэдгийг авч үзмээр байна.

Г. Сүхбаатарын хэлдэгтэй уялдуулж хэлэхэд сүүлийн үед түүхч биш хүмүүс их чухал санаа гаргаж ирж байна. Одоо түүхчид маань нэлээн гүнзгий судлах хэрэгтэй болж байх шиг байна.

VIII Богд үнэхээр ҮЭЧХ-ийг толгойлж байсан байх. Монгол, Төвд хоёр Манжийн эсрэг хүчээ нэгтгэн тусгаар тогтнох зорилготой байсан учир XIII Далай лам, VIII Богд хоёр Их Хүрээний газар санамсаргүй уулзаад маргаж салсан билээ. Энэ бол нарийн асуудал. Түүхийн ийм зангилаа асуудлаар саналаа солилцож байх нь зүйтэй байна. 1911 онд өрнөсөн тэр их тэмцлийг зөвхөн хөдөлгөөн гэхгүй хувьсгал гэж үзэх тухай Жамсрангийн санаатай санал нийлж байна. Зөвхөн тусгаар тогтнолоо олох гэсэн биш, цаашдын нийгмээ шинэчлэх зорилготой байсан юм.

Улсын нэрийн талаар, сүүлийн үед зарим зохиолд «Хаант Монгол улс» гэж нэрлээд байгаа. Монгол улс гэдэг нь яриангүй. Ямар Монгол улс гэдгийг нь гаргаж өгөх нь зөв болов уу. Зөвхөн Хаант улс гэх юм бол Түрэгийн хаант улс, Уйгурын хаант гэдэг шиг жижиг болоод ялгагдахгүй болж байна. Улсын нэрийг олноо өргөгдсөн Монгол улс гэхэд буруудахгүй. Мөн Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улс гэвэл нэн тодорхой болох мэт санагдана.

1911 оны хувьсгалыг 1911—1912 оны хөдөлгөөн гэх үү, 11—13-оны хувьсгал гэх үү? 1912 онд уг хөдөлгөөн Ар Монголд бүрэн ялсан болохоор 1911—1912 оны хөдөлгөөн, 1911 оны хувьсгал гэх нь зүйтэй болов уу. Тэр хөдөлгөөн чухамдаа хөрөнгөтний хувьсгалын чиглэл бүхий үндэсний хувьсгал байсан болтой байдаг. Хэрэв Олноо өргөгдсөн Монгол улс 1919 онд устгагдаагүй байсан бол тус орны феодал-хөрөнгөтний замаар замнах шинж төлөв үзэгдэж байсан болно.

Э.Чимэдцэрэн (дэд эрдэмтэн). Яригдаж байгаа энэ сэдэв бол манай түүхийн гол сэдвийн нэг мөн. Гэтэл саяхан болтол уг сэдвийн ач холбогдлыг төдийлөн анхаарч ирээгүй, ингэс тэгс хийгээд дурдах төдий л өнгөрч байсан нь одоо болтол тухайн түүхэн үеийн нэрийг нь зөв тогтоож чадаагүй байгаагаас тодорхой. Харин өнөөдөр уг сэдвийг нилээд шинэлэг байдлаар дүгнэн ярилцаж байгаа нь сайшаалтай бөгөөд сонирхолтой байна.

Миний бие судлаачийн үүднээс биш, зөвхөн олон жил түүхийн хичээлийг заамар болж байсны хувьд зарим санаа хэлье гэж бодож байна.

1. «1911—1912 оны үнэсний эрх чөлөөний хөдөлгөөн» бол монголын ард түмний манжийн колончлолын эсрэг 220 гаруй жил явуулсан тусгаар тогтнолын тэмцлийн үр дүн, түүний нэгэн үеийн оргил нь гэж үзэлтэй. Гэхдээ урьд гарч байсан хөдөлгөөнөөс зарчмын хэд хэдэн онцлогтой болов уу! Үүнд:

1. Түрүү түрүүчийн хөдөлгөөнөөс энэ удаагийн тэмцэл нь хамарсан хүрээгээрээ (газар, нутаг, анги давхарга г.м.) өргөн, нийтийн шинжтэй байсан.

2. Зохион байгуулалтын хувьд нэлээн нарийн, нэгдсэн удирдлагатай, тэмцлийн хувьд хурц байжээ.

3. Шийдвэрлэсэн асуудал, өгөөж үр дүнгээрээ урьдахийг бодвол хөдөлгөөнийхөө үндсэн зорилтыг хэрэгжүүлсэн юм.

4. Дотоод, гадаад нөхцөлийг зөв дүгнэж, цаг хугацааг айхтар зөв сонгож чадсан байлаа.

II. Эдгээрээс дүгнэн үзвэл 1911 — 1912 оны үндэсний эрх чөлөөний тэмцэл бол зөвхөн хөдөлгөөн төдий биш «үндэсний эрх чөлөөний хувьсгал» байсан гэсэн Л. Жамсрангийн санал зөв шиг санагдана.

III. 1911— 1912 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын үргэлжилсэн хугацааг 1911-1913 он хүртэл үргэлжилсэн гэдэг илтгэгчийн дүгнэлт зөв байх, түүгээр ч үл барам бүр цааш нь 1915 оны гурван улсын гэрээгээр хязгаарласан ч болохгүй гэх газаргүй мэт.

IV. Манай судлаачид энэ хувьсгалыг хаант Оросын тусламжтайгаар хийсэн юм шиг бичиж, ярьдаг нь зуршил болжээ. Миний бодоход Хаант Орос зэвсгийн болон аль нэг талаар туслаагүй, харин энэ хэрэгт өөрийнхөө эрх ашгийн үүднээс хөндлөнгөөс оролцсоноороо манай ард түмний тусгаар тогтнолын хөдөлгөөнд ихээхэн хохирол үзүүлсэн шиг байдаг. Тэгэхээр энэ тэмцэл бол монголчуудын өөрсдийн хүчээр хийгдсэн хувьсгал болох нь тодорхой.

V. 1911— 1915 оны эрх чөлөөний хувьсгалын удирдагчийн үйл ажиллагааг үнэн зөвөөр товойлгон гаргах, шийдвэрлэх хүч болж байсан бусад зүтгэлтнийг (Өвөр Монгол, Буриад, Шинзяны монголчууд, Халимагаас оролцсон) тодруулах, тэгвэл энэ хувьсгал бол зөвхөн халхын хэмжээний бус бүх монгол угсаатныг хамарсан асар том хувьсгал байсныг харуулж болох талтай.

VI. Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ялалтаар дахин сэргээгдсэн Монгол улсынхаа албан ёсны нэрийг зөв тогтоох. Бид нэг хэсэг «автономит Монгол», «Богд Хаант Монгол улс» гэж нэрлэж байв. Гэтэл «Богд Хаант Монгол улс» гэдэг нэр бол 1986 оноос л өгсөн нэр шүү дээ! Тэхээр «Олноо өргөгдсөн Монгол улс» гэдэг нэрээр нэрлэе гэсэн илтгэгчийн санал зөв байх аа.

VII. 1911—1915 оны Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хувьсгал бол 1921 оны ардын хувьсгалын суурь дэвсгэр, бэлтгэл, сургамж, туршлага болсон ач холбогдлыг нарийвчлан гаргаж өгөх нь. Манай түүх судлалд чухал байх аа. Энэ хоёр хувьсгалыг уялдаа холбоотой үзэх нь чухал юм шиг санагдах юм.

С. Идшинноров (Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан). Монголын түүхийн шинжлэх ухаанд бий болсон гажуудлыг засах, үнэн түүхээ боловсруулахыг чармайж буй өнөө үед түүхчид түүхийн зангилаа асуудлаар санал солилцох явдал их чухал байна.

1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний түүхийг гүнзгийрүүлэн судалж, сонирхолтой санал дэвшүүлж буй Жамсран гуайд болон энэ ярилцлагыг зохион байгуулсан Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнд талархаж байна.

1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн бол XX зууны эхэн үеийн Монгол орны түүхэн дэх хоёр том үйл явдлын нэг яриагүй мөн. Нөгөөх нь 1921 оны үндэсний ардчилсан хувьсгал байлаа. 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн гэж нэрлэх нь уг үйл явдлын түүхэн ач, холбогдлыг гүйцэд илэрхийлж чадахгүй байна гэдэгтэй санал нэгтэй байна. Учир нь «хувьсгал» гэдгийг дан ганц анги нийгмийн асуудалд хэрхэн хандаж, яаж шийдвэрлэсэн бэ гэдгээр хэмжих нь хэтэрхий өрөөсгөл юм. Нийгмийн хувьсгалаас гадна үндэсний хувьсгал байдаг. 1911 онд Монголд болсон үйл явдал бол чухамхүү үндэсний асуудлыг шийдэх, өөрөөр хэлбэл, 200 гаруй жилийн дараа Манжийн дарлалыг түлхэн унагааж, үндэсний төр улсынхаа тусгаар тогтнолыг сэргээх, бие даасан Монгол улсыг байгуулах зорилтыг шийдэх тухай асуудал байлаа. Монгол орон ийм урт удаан хугацааны дараа төрийн тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан, түүнийг бэхжүүлэхийн төлөө зохих тэмц-

лийг явуулсан, түүнээс монгол туургатны эрх чөлөөний тэмцэлд үзүүлсэн нөлөө нь үнэхээр хувьсгалт шинж чанартай байсан.

Хэрэв 1911 оны үйл явдал байгаагүйсэн бол 1921 оны хувьсгал ч гарахгүй байсан. 1911 оны үйл явдлыг төгсөөгүй, гадаад дотоодын олон учир шалтгааны улмаас тасалдсан хувьсгал байсан гэж үзэх нь зүйтэй болов уу. Үүнтэй холбогдуулан 1921 оны хувьсгалыг үндэсний ардчилсан хувьсгал гэж үзэх саналыг дэмжидгээ хэлье. 1921 оноос 1920-оод оны эцэс хүртэл тус оронд хэрэгжүүлсэн арга хэмжээ төрийн бодлогод үндэсний зорилтыг ардчилсан зорилттой нягт уялдаатай авч үзэж байсан нь тодорхой харагддаг.

Харин уг явдлыг 1911-1912 оны гэх юмуу? Эсвэл 1911—1915 оны гэж нэрлэж он цагийн эцсийн хязгаарыг тогтоон заах шаардлага байна уу? Ерөөс 1911 оны гэж нэрлэж хэвшвэл ямар бол гэж бодох юм. Бас улсын нэрийг «Олноо өргөгдсөн Монгол улс» гэж нэрлэх санаа «Богд хаант» хэмээх зохиомол нэрээс яриагүй дээр юм. Гэвч «олноо өргөгдсөн» гэдэг нь оны цол шүү дээ. Дорно дахины уламжлал ёсоор оны цол, улсын нэр хоёр ондоо. Иймд судалгаа гүнзгийрэхээр бидний бичиж байгаа нэр буруу байна гэсэн шүүмжлэл дахин гарч ирж болох юм. Харин «Шашин төрийг хослон барих хаант Монгол улс» гэвэл хэдийгээр олон үгтэй урт боловч тухайн үеийн төрийн хэлбэр, Шинж чанарыг тодорхой тусган илэрхийлэх юм биш биз. Тухайн үеийн архивын бичиг баримт, ном зохиолд ч энэ нэр томъёо хэрэглэгдэж байсан билээ. Эсвэл зүгээр л «Монгол улс» гэж нэрлэж болох бус уу? Зарим хүн урдах үеэсээ ялгагдахгүй байна гэх байх. Гэвч 1911 онд шинээр сэргээн байгуулагдсан Монгол улсын зүтгэлтнүүд урьдын Монголын үндэсний төрийг сэргээлээ гэж үзэж байснаас гадна, 1921 оноос хойш ч 1940 он хүртэл «Монгол улсын төддүгээр он» хэмээн 1911 оноос эхлэн тоолж албан бичиг, аман ярианд өргөн хэрэглэж байлаа. Энд «Монгол улс» гэдгийг гол болгож байснаас бус хаантай юу, хаангүй юу, хаан нь олноо өргөгдсөн эсэх, ямар эрх хэмжээтэй байсныг төдий л чухалд үзэхгүй байсан мэт.

Д. Хүүхэнбаатар (МУИС, доцент, дэд эрдэмтэн). Монголд XX зууны эхээр гарсан улс төрийн том үйл явдал, улс төрийн сэргэн мандалтын эхэн бол 1911—1912 оны үндэсний эрх чөлөөний хувьсгал байлаа.

Энэ нь харийн дарлалаас ангижрах тэмцлийг цэрэг зэвсгийн хүчээр шийдэж, тусгаар тогтнолоо ч тэгж хамгаалсан. Нийгмийг ардчилахын тулд хөрөнгөтний хувьсгалын жишээгээр аажим хувьсгалаар шинэчлэх оролдлого хийсэн юм. Энэ хувьсгал Орос, Хятадын түрэмгий бодлого, хуйвалдаан, хамжлагат ёсны дэглэм хэвээр байснаас гүнзгийрэн туйлдаа хүрч тавьсан зорилтоо хэрэгжүүлж чадаагүй юм. Тогтсон төрөөн Олноо өргөгдсөн Монгол улс гэж нэрлэх хаант төрийг сэргээсэн нь тусгаар тогтнолын бэлэгдэл болжээ. Тусгаар тогтнолын төлөө анх үндэсний эв нэгдлийг эрхэмлэн гарч ирсэн боловч шар, харын тэмцэл гүнзгийрэн дотор зуураа хямарсан, гадаад бодлогодоо түшиглэх улс гүрний хувьд санал нэгдээгүй зэрэг шалтгааныг Орос, Хятад улс овжин ашиглаж, автономит улс болгон улмаар түүнийг мөхөөхөд хүргэсэн. Автономит гэдэг нь Орос Хятад хоёр улс хуйвалдаж мэхэлсэн хэрэг мөн.

1911—1912 оны үндэсний эрх чөлөөний хувьсгал ба 1921 оны үндэсний ардчилсан хувьсгал нь түүхэн залгамж холбоотой. Энэхүү хоёр хувьсгал тусгаар тогтнолоо олох нэг зорилготой бөгөөд 1911 — 1921 оны хувьсгалд идэвхтэй оролцсон Богд Жавзандамба хутагт Жалханз, хутагт Дамдинбазар, Ширнэндамдин, Б.Цэрэндорж, Егүзэр хутагт Гал-

сандаш, Гомбо Идшин гүн, Хатанбаатар Магсаржав, Д. Сүхбаатар, Д. Лосол зэрэг олон хүн 1921 оны хувьсгалын идэвхтэй тэмцэгчид, дэмжигчид байсан нь санамсаргүй зүйл биш ээ. Ер нь 1921 оны ардын хувьсгал нь 1911 — 1921 оны үндэсний хувьсгалын шууд үргэлжлэл, түүний ялалт болсон бөгөөд хамжлагат ёсыг халснаар урагшаа том алхам хийсэн нийгмийн хувьсгалын шинжийг агуулжээ. 1928 оныг хүртэл хувьсгалын үндэсний ардчилсан шинж хадгалагдсаар байсан гэж үзэж болно.

НҮҮДЭЛЧИН БОЛОН СУУРЬШМАЛ УЛС ҮНДЭСТНҮҮДИЙН УЛС ТӨР, СОЁЛЫН НӨЛӨӨЛЛИЙН АСУУДАЛД

Н. Ариунгуа*

Нүүдэлчдийн нийгэм нь бусад нийгэм улс үндэстнүүдээс тасархай нэгэн хаалттай систем байгаагүй бөгөөд нүүдэлчдийн аж амьдрал нь чухамдаа гадаад ертөнцтэй харьцах нэгэн хэлбэр байжээ. Нүүдлийн мал аж ахуйн үйлдвэрлэл нь явцуу нэг талыг барьж хөгжсөн нь суурин улс үндэстнүүдтэй харьцах зайлшгүй нөхцөлийг бий болгож байжээ. Улмаар суурьшмал улс үндэстнүүдтэй харьцах харьцаа нь юуны өмнө тэдний эдийн засгийн сонирхлоос үүдэн гарч байсан буюу тэрхүү харилцаа нь худалдаа арилжаа мөн бараа таваар олзлон авах зорилгоор хийж байсан дайн байлдааны хэлбэрээр илэрч байлаа. Нүүдэлчид суурин улс үндэстнүүдтэй харьцах явцад тэдний улс төр, соёлын нөлөөг хүртэн байсны зэрэгцээ мөн өөрийн зүгээс ч нөлөөлсөөр иржээ. Чингэхдээ нүүдэлчид өөрийн аж ахуйн хэв шинжийн онцлогийн улмаас бусад улс үндэстнүүдийн соёлын нөлөөг өвөрмөц байдлаар хүлээн авч байсныг тэмдэглэх хэрэгтэй. Нүүдэлчдийн бусдаас хүлээн авсан соёлын нөлөөллийг үндсэн 2 хэсэгт хувааж болох юм. Нэгдүгээрт, эдийн соёлын нөлөөлөл, хоёрт оюун санаа, үзэл суртлын нөлөөлөл болно. Суурьшмал улс үндэстний соёлын нөлөөлөл нь гол төлөв эдийн соёлын хүрээг хамарч байсан бөгөөд чингэх нь нүүдэлчдийн эрхэлж байсан аж ахуйн өвөрмөц байдалтай холбоотой байсан ажээ. Дан ганц мал аж ахуй эрхэлж байсан нүүдэлчид газар тариалангийн аж ахуйгаас бараа таваараар гачигдан суурьшмал улс үндэстнүүдтэй худалдаа арилжаа хийх шаардлагатай байсан ажээ. Иймээс суурьшмал улс үндэстнүүдийн эдийн соёлын нөлөө нүүдэлчдийн нийгэмд аяндаа бий болж эхэлсэн байна. Харин суурьшмал улс үндэстний үзэл суртал нүүдэлчдийн дунд дэлгэрч тэдний оюун санааг эзэмдэж чадаагүй. Учир нь нүүдэлчдийн аж ахуйн хэвшинж өвөрмөц ахуй, оюун санааны өвийг бий болгож байсан хийгээд газар тариалангийн үндсэн дээр бүрэлдэн бий болсон үзэл суртал нүүдэлчдийн оюун санаанд нийцэж тэдний оюуны эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байлаа. Тухайлбал, хөрш зэргэлдээ Хятад улсын үзэл суртлын үндэс болсон Күнзийн сургаал нүүдэлчдийн дунд дэлгэрч чадаагүй юм. Мөн хятад бичиг үсгийг нүүдэлчид хүлээж аваагүй бөгөөд өөрийн бичиг үсгийг зохиох мөн өөр хоорондоо бичиг үсэг зээлдэн авч байжээ. Хойт зүгийн нүүдэлчдийн хувьд

* Н. Ариунгуа—Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан